

**ГАРЧИГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

|      |   |     |
|------|---|-----|
| 94.  | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай  | 188 |
| 95.  | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                     | 215 |
| 96.  | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай   | 216 |
| 97.  | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай                   | 217 |
| 98.  | Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай                       | 217 |
| 99.  | Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                   | 227 |
| 100. | Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай                      | 228 |
| 101. | Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай                               | 228 |
| 102. | Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай                              | 228 |
| 103. | Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай                | 229 |
| 104. | Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 229 |



|      |  |     |
|------|--|-----|
| 105. | Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 230 |
| 106. | Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 230 |
| 107. | Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 231 |
| 108. | Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 231 |
| 109. | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай                             | 232 |
| 110. | Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай   | 232 |
| 111. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 233 |
| 112. | Терроризмтой тэмцэх тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай  | 233 |
| 113. | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай                                   | 233 |
| 114. | Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 234 |
| 115. | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 234 |
| 116. | Төрийн нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 235 |



|      |  |  |     |
|------|--|--|-----|
| 117. | Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай   |  | 235 |
| 118. | Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай   |  | 238 |
| 119. | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай |  | 238 |
| 120. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай   |  | 239 |
| 121. | Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай   |  | 239 |
| 122. | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  |  | 240 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

|      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 123. | Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай  | Дугаар 18 | 241 |
| 124. | “Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 19 | 252 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

|      |   |            |     |
|------|---|------------|-----|
| 125. | Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай | Дугаар 317 | 253 |
| 126. | Журам шинэчлэн батлах тухай                           | Дугаар 393 | 275 |



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл авах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомж

2.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Ашигт малтмалын тухай<sup>2</sup>, Газрын тухай<sup>3</sup>, Газрын хэвлийн тухай<sup>4</sup>, Байгаль орчныг хамгаалах тухай хууль<sup>5</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Эмчилгээний зориулалтаар шавар, элсийг ашиглахтай холбогдсон харилцааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

3.3.Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно.

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Ашигт малтмалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Газрын хэвлийн тухай хууль “Хууль, зарлиг, тогтоолын эмхэтгэл”-ийн 1988 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup>Байгаль орчныг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“түгээмэл тархацтай ашигт малтмал” гэж зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий элс, хайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайрганы зориулалттай барилгын чулууны хуримтлалыг;

4.1.2.“түгээмэл тархацтай ашигт малтмал хайх” гэж түгээмэл тархацтай ашигт малтмалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг;

4.1.3.“түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах” гэж түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу газрын гадаргуу, хэвлийгээс ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг;

4.1.4.“түгээмэл тархацтай ашигт малтмалын орд” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд бүрэлдэн тогтож чанар, нөөц нь тодорхойлогдсон, үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлалыг;

4.1.5.“тусгай хэрэгцээний газар” гэж Газрын тухай хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагаас улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон газрыг;

4.1.6.“түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуульд заасны дагуу ашигт малтмал хайх эрх олгосон баримт бичгийг;

4.1.7.“түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуульд заасны дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичгийг;

4.1.8.“түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай” гэж энэ хуулийн 4.1.6-д заасан тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг;



4.1.9.“уурхайн талбай” гэж энэ хуулийн 4.1.7-д заасан тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг;

4.1.10.“уурхайн эдэлбэр” гэж уурхайн талбайтай давхацсан, ашигт малтмал олборлох геологийн тогтоцын хэсгийг;

4.1.11.“түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр” гэж тусгай зөвшөөрлийг хүчин төгөлдөр байлгах зорилгоор эзэмшигчээс нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн<sup>6</sup> 35.6-д заасны дагуу төлөх төлбөрийг;

4.1.12.“түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал хайх, ашиглах эрх авсан хуулийн этгээдийг;

4.1.13.“хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн<sup>7</sup> 33.1-д заасан компани, нөхөрлөлийг.

## **5 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын өмчлөл**

5.1.Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмал төрийн өмч мөн.

5.2.Төр өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй.

## **6 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглахад тавих ерөнхий шаардлага**

6.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно.

6.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаанд энэ хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангасан байна.

<sup>6</sup>Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup>Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



6.3.Нэг тусгай зөвшөөрлийг зөвхөн нэг хуулийн этгээдийн нэр дээр олгоно.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТАЛААРХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

#### **7 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

7.1.Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглахтай холбогдсон бодлогыг тодорхойлно.

7.2.Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавина.

7.3.Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар тодорхой нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглахыг, эсхүл хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хязгаарлах буюу хориглоно.

#### **8 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

8.1.Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.

8.2.Улсын тусгай хамгаалалттай болон түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газраас бусад тусгай хэрэгцээний газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэнэ.

#### **9 дүгээр зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

9.1.Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлаар доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах.

9.2.Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлаар доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



9.2.1.барилгын салбарт ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын эрэлт, нийлүүлэлтийн судалгааг хийж, төлөвлөлтийг уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

### **10 дугаар зүйл.Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

10.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх;

10.1.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн зураг зүйн бүртгэл хөтлөх;

10.1.3.ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасан талбайд тусгай зөвшөөрөл олгох боломжтой эсэх талаар дүгнэлт гаргаж Засаг даргад хүргүүлэх;

10.1.4.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах тухай шийдвэр гаргах;

10.1.5.нийслэл болон аймгуудын нутаг дэвсгэрийг хамарсан түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журам батлах.

10.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ.

### **11 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

11.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:





11.1.1.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах;

11.1.2.Газрын тухай хуульд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай, ордод хамаарч байгаа газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах;

11.1.3.палеонтологи, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэсэн эсэх, авран хамгаалах ажиллагаа шаардлагатай эсэхэд хяналт тавих.

11.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

11.2.2.харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргасан тохиолдолд уг зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

11.2.3.хүний эрүүл мэнд, байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалт болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

11.2.4.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдлийг хянах;

11.2.5.харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;

11.2.6.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн гүйцэтгэлийг хянах.



**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН  
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

**12 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын  
хайгуулын тусгай зөвшөөрөл авахад  
тавих шаардлага**

12.1.Ашигт малтмалын тухай хуулийн 17.1-17.3-т заасан шаардлагыг биелүүлнэ.

12.2.Нэг тусгай зөвшөөрлөөр олгох түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайн хэмжээ Ашигт малтмалын тухай хуулийн 17.4-т заасны дагуу 25 гектараас багагүй, 400 гектараас ихгүй байна.

**13 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын  
хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн  
өргөдөл гаргах журам**

13.1.Энэ хуулийн 6.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлд заасан шаардлага хангасан бөгөөд хамгийн түрүүнд өргөдөл гаргаж бүртгүүлсэн хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоно.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан хуулийн этгээд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан маягтын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргад гаргах бөгөөд түүнд доор дурдсан баримт бичгийг хавсаргана:

13.2.1.тухайн хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, факсны дугаар;

13.2.2.тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

13.2.3.энэ хуулийн 12.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зураг ба тухайн зураг дээр тэмдэглэсэн уг талбай байрших аймаг, сум, дүүргийн нэр;

13.2.4.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.5-д заасан үйлчилгээний хөлс төлсөн баримт;



13.2.5. тухайн хуулийн этгээд энэ хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангаж байгааг нотлох баримт.

#### **14 дүгээр зүйл. Өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа**

14.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 13.2-т заасан өргөдлийг хүлээн авмагц доор дурдсан ажиллагаа явуулна:

14.1.1. өргөдлийг өргөдөл бүртгэх дэвтэрт бүртгэж, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудас тус бүрд бүртгэлийн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх;

14.1.2. тухайн өдөр хамгийн түрүүнд болон сүүлд бүртгэсэн өргөдөлд тусгай тэмдэглэгээ хийх;

14.1.3. өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 12.1, 12.2, 13.2-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд бүртгэсэн даруйд нь анхан шатны шүүлт хийж, шаардлагыг хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, татгалзсан шалтгаан, үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх;

14.1.4. энэ хуулийн 14.1.3-т заасны дагуу анхан шатны шүүлт хийсний дараа өргөдөлд дурдсан талбай нь ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон, түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцаж байгаа эсэхийг тогтоолгох өргөдлийг холбогдох материалын хамт төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх.

14.2. Төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдөрт багтаан энэ хуулийн 14.1.4-т заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой, эсхүл боломжгүй талаар мэдэгдэнэ.

14.3. Өргөдөлд дурдсан талбай нь ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан бол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүй тухай өргөдөл гаргасан этгээдэд аймаг, нийслэлийн Засаг дарга бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ.



14.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 14.2-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч ажлын 10 өдрийн дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

14.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд төлөх тухай өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

14.6.Энэ хуулийн 14.5-д заасан шийдвэр гарснаас хойш өргөдөл гаргасан этгээд нэг сарын дотор тусгай зөвшөөрлийг аваагүй, эсхүл эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд төлөөгүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга өргөдлийг бүртгэлээс хасаж өргөдөл гаргасан этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэнэ.

14.7.Өргөдөл гаргасан этгээд эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд төлсөн бол аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын таван өдөрт багтаан түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.

14.8.Аймаг, нийслэлийн Засаг дарга барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, тухайн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай байрших аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагад түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон тухай мэдэгдэж, төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

14.9.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон талбайн булангийн цэгийн солбицлуудыг тэмдэглэх бөгөөд уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна.

14.10.Ашигт малтмалын тухай хуулийн 19.12, 20.1 дэх хэсэг түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахад хамаарахгүй.



**15 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх**

15.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч доор дурдсан эрх эдэлнэ:

15.1.1.хайгуулын талбайн хилийн дотор энэ хуулийн дагуу зөвхөн түгээмэл тархацтай ашигт малтмал хайх;

15.1.2.энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр хайгуулын талбайн аль ч хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрлийг онцгой эрхийнхээ дагуу авах;

15.1.3.энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг хоёр жилийн хугацаагаар нэг удаа сунгуулах.

**16 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах**

16.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас нэг сарын өмнө түүнийг эзэмшигч нь хугацааг сунгуулах тухай өргөдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад гаргаж, түүнд доор дурдсан баримт бичгийг хавсаргана:

16.1.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

16.1.2.үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөр төлсөн тухай баримт;

16.1.3.байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн батлуулсан баримт;

16.1.4.хайгуулын тусгай зөвшөөрлийг сунгахаас өмнөх үе шатны ажлыг гүйцэтгэсэн тухай тайлан, түүнийг хүлээлгэн өгсөн баримт.

16.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 16.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтааж тусгай зөвшөөрөл



эзэмшигч нь мөн хуулийн 6.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянаж, зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг энэ хуулийн 15.1.3-т заасан хугацаагаар сунгаж, энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.

16.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгамагц энэ тухай барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

16.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 6.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга хугацаа сунгахаас татгалзаж энэ тухай өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

#### **17 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад тавих шаардлага**

17.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах эрхтэй.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан өргөдөлд уурхайн талбайн булангийн цэгийг төрийн захиргааны байгууллагаас баталсан нэг загварын газрын зураг дээр тэмдэглэж, солбицлуудыг градус, минут, секундээр тодорхойлж хавсаргана.

17.3.Уурхайн талбай нь Ашигт малтмалын тухай хуулийн 24.4, 24.5-д заасан шаардлагыг хангасан байна.

#### **18 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам**

18.1.Энэ хуулийн 17.1, 17.2-т заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргад гаргах бөгөөд түүнд доор дурдсан баримт бичгийг хавсаргана:



18.1.1.хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, факсны дугаар, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны нэрийг тусгасан тодорхойлолт;

18.1.2.тухайн хуулийн этгээд энэ хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангаж байгааг нотлох баримт;

18.1.3.энэ хуулийн 17.3-т заасан шаардлагын дагуу хийгдсэн талбайн зураг ба тухайн зураг дээр тэмдэглэсэн уг талбай байрших аймаг, сум, дүүргийн нэр;

18.1.4.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.5-д заасан үйлчилгээний хөлс төлсөн баримт;

18.1.5.хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээн авсан тухай төрийн захиргааны байгууллагын шийдвэр;

18.1.6.хайгуулын ажлын явцад байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримт.

## **19 дүгээр зүйл.Өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа**

19.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 18.1-д заасан өргөдлийг хүлээн авмагц доор дурдсан ажиллагаа явуулна:

19.1.1.өргөдлийг өргөдөл бүртгэх дэвтэрт бүртгэж өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудас тус бүрд бүртгэлийн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх;

19.1.2.бүртгэсэн даруйд өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг энэ хуулийн 17.3, 18.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд анхан шатны шүүлт хийх.

19.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.1.2-т заасан анхан шатны шүүлт хийсний дараа доор дурдсан зүйлийг тодруулна:

19.2.1.хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч уг зөвшөөрлөөр олгогдсон талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан бол өргөдөл гаргасан талбай нь хайгуулын талбайн хилийн дотор бүрэн багтаж байгаа эсэх;



19.2.2. өргөдөл гаргасан талбай нь тусгай хэрэгцээ болон нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай ямар нэгэн байдлаар давхцаж байгаа эсэх;

19.2.3. хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсч болох байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэх.

19.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.1, 19.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 15 өдөрт багтаан доор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

19.3.1. өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 17.3, 18.1-д заасан шаардлагыг хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, татгалзсан шалтгаан, үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх;

19.3.2. хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд төлүүлэх;

19.3.3. өргөдөлд дурдсан талбай нь ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайн аль нэг хэсэгтэй давхцсан бол ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, татгалзсан шалтгаан үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, энэ тухай өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэх.

19.4. Энэ хуулийн 19.3.2-т заасан онцгой эрхийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан эзэмшигч мөн хуулийн 24.1-д заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлөөгүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга өргөдлийг бүртгэлээс хасаж, өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, энэ тухай өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэнэ.

19.5. Өргөдөл гаргасан этгээд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 19.3.2-т заасны дагуу хийснээс хойш ажлын таван өдөрт багтаан аймаг, нийслэлийн Засаг дарга ашиглалтын тусгай зөвшөөрлийг 15 жилийн хугацаагаар олгоно.





19.6.Ашиглалтын тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигч этгээдийн нэр, хаяг болон уурхайн талбайн булангийн цэгийн солбицлуудыг тэмдэглэх бөгөөд уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тэмдэглэх зориулалт бүхий хавсралттай байна.

19.7.Аймаг, нийслэлийн Засаг дарга ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 10 өдөрт багтаан барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага, татварын асуудал эрхэлсэн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн Засаг даргад энэ тухай тус тус мэдэгдэж, төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл болон уурхайн талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

19.8.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3.1, 19.3.3, 19.4-т заасан шийдвэр гаргасан бол өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг өргөдөл гаргасан этгээдэд буцааж өгнө.

## **20 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

20.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч доор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

20.1.1.тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа түгээмэл тархацтай бүх төрлийн ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах;

20.1.2.энэ хуулийн зургаадугаар бүлэгт заасан үүргийг биелүүлэх;

20.1.3.уурхайн эдэлбэрээс олборлосон бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр борлуулах;

20.1.4.уурхайн талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул явуулах;

20.1.5.түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг ашигт малтмалын нөөцийн хэмжээнээс хамааран 10, 10 жилээр сунгуулах;



20.1.6.ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор уурхайн талбайд нэвтрэн орох, дамжин өнгөрөх, шаардлагатай барилга байгууламж барих, түүнийг ашиглах;

20.1.7.энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын өмчлөл, эзэмшилд байгаа газарт түүний өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрсний дагуу нэвтрэх, дайран өнгөрөх;

20.1.8.уурхайн эдэлбэрээс олборлосон бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь стандартын шаардлагад нийцсэн байх;

20.1.9.холбогдох хууль тогтоомжийн дагуу газар, ус ашиглах.

20.2.Газар өмчлөгч, эзэмшигч нь тухайн газарт байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиг олох зорилгогүйгээр өөрийн ахуйн хэрэгцээнд ашиглаж болно.

## **21 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах**

21.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас нэгээс доошгүй жилийн өмнө түүнийг эзэмшигч нь төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу хугацаа сунгуулах тухай өргөдөл гаргаж, түүнд доор дурдсан баримт бичгийг хавсаргана:

21.1.1.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

21.1.2.үйлчилгээний хөлс болон тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн баримт;

21.1.3.байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу хянасан тухай баримт.

21.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 21.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч уг зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах нөхцөлийг хангасан



эсэхийг хянаж, зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 20.1.5-д заасан хугацаагаар сунгаж, энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэж, өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

21.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан тухай шийдвэрийг түүнийг гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан энэ хуулийн 19.7-д заасан байгууллагуудад мэдэгдэнэ.

**ТАВДУГААР БҮЛЭГ  
ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН  
ХАЙГУУЛЫН БОЛОН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИХ ЭРХИЙГ  
ХАДГАЛАХ НӨХЦӨЛ**

**22 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах**

22.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд зөрчвөл энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцална.

**23 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийн төлбөр**

23.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.6-д заасны дагуу жил бүр төлнө.

**24 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх**

24.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 14.5, 19.3.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлнө.

24.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа жилийн төлбөрийг тухайн тусгай зөвшөөрлийг олгосон өдрөөс эхлэн тооцож жил бүр урьдчилан төлнө.

24.3.Тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээг тогтоохдоо уг төлбөрийг төлөх үед тусгай зөвшөөрлийн бүртгэлд бүртгэгдсэн талбайн уурхайн эдэлбэрт ногдох талбайн хэмжээг үндэслэх бөгөөд тухайн жилд төлбөрийн хэмжээг өөрчлөхгүй.



## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ**

### **25 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг**

25.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглахдаа энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг биелүүлж ажиллах бөгөөд зөрчвөл энэ хуулийн 44.1.4-т заасан хариуцлага хүлээнэ.

25.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч доор дурдсан баримт бичгийг хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа газар дээр байлгана:

25.2.1.хайгуулын тусгай зөвшөөрлийн хуулбар;

25.2.2.байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан;

25.2.3.сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулсан хайгуулын ажлын төлөвлөгөө.

25.3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Ашигт малтмалын тухай хуулийн 35.3.1-35.3.7-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

25.4.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах явцад өөр төрлийн ашигт малтмал, түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд үйл ажиллагаагаа зогсоож аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ.

25.5.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн<sup>8</sup> 17.10-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

25.6.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Газрын хэвлийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж ажиллана.

<sup>8</sup>Соёлын өвийг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



## **26 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах**

26.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 27, 28 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.

26.2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагаас зөвшөөрөл авалгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа эхлэхийг хориглох бөгөөд тухайн асуудлаар маргаан гарвал мэргэжлийн хяналтын байгууллагад гомдол гаргаж болно.

## **27 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг**

27.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар доор дурдсан үүрэг хүлээнэ:

27.1.1. тусгай зөвшөөрөл авснаас хойш 60 өдрийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулж сум, дүүргийн Засаг даргаар батлуулах;

27.1.2. энэ хуулийн 27.1.1-д заасан төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах;

27.1.3. энэ хуулийн 27.1.1-д заасны дагуу батлагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

27.1.4. хайгуулын ажлын явцад үүссэн байгаль орчны сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний жилийн тайланд тусгах бөгөөд уг тайланг байгаль орчны хяналтын алба болон тухайн сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх;

27.1.5. энэ хуулийн 27.1.4-т заасан тайланд байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх чиглэлээр төлөвлөгөөнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай саналыг тусгаж, уг өөрчлөлтийг сум, дүүргийн Засаг даргаар батлуулах;



27.1.6.байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд хайгуулын талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгох;

27.1.7.байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх.

27.2.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 27.1.1, 27.1.5-д заасан төлөвлөгөө, түүний өөрчлөлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

27.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 27.1.7-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.

27.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 27.1.7-д заасан хөрөнгийг түүнд буцааж өгнө.

**28 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалах талаар түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг**

28.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Ашигт малтмалын тухай хуулийн 39.1-д заасан үүрэг хүлээнэ.

**29 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах шинэчилсэн үнэлгээ, төлөвлөгөөг хянуулах**

29.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө сум, дүүргийн Засаг даргад батлуулахаар хүргүүлнэ.

29.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон



байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

29.3.Энэ хуулийн 29.1-д заасан төлөвлөгөөг энэ хуулийн 27.2-т заасны дагуу батална.

### **30 дугаар зүйл.Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх**

30.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 41.1-д заасны дагуу хохирлыг нөхөн төлнө.

### **31 дүгээр зүйл.Эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй ажиллагааг хангах**

31.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагчийн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой үйл ажиллагаа явуулна.

### **32 дугаар зүйл.Уурхайг хаах үед тавих шаардлага**

32.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол Ашигт малтмалын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### **33 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр**

33.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө.

33.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү байна.

### **34 дүгээр зүйл.Мэдээ, тайлан гаргах**

34.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайлан, төлөвлөгөөг доор дурдсан хугацаанд үнэн зөв гаргаж аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын газарт хүргүүлнэ:



34.1.1. хайгуулын ажлын төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 60 өдрийн дотор;

34.1.2. хайгуулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу, хайгуулын үе шатаар нь ангилан гаргаж, тайлан гаргасан хугацаанаас хойш 60 өдрийн дотор.

34.2. Энэ хуулийн 34.1.2-т заасан тайланд тухайн талбайд хийгдсэн өрөмдлөг болон бусад бүх төрлийн ажлын тоо хэмжээ, өртөг, зардал, ажиллах хүчтэй холбогдсон мэдээ, түүнчлэн хайгуулын ажлын үр дүн, тухайн талбайд хийгдсэн ажлын зургийг хавсаргах бөгөөд түүнийг улсын геодезийн зураглалын тулгуур сүлжээтэй холбосон байна.

34.3. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ордын нөөц, хайгуулын үр дүнгийн нэгдсэн тайланг батлагдсан маягт, шаардлагад нийцүүлэн боловсруулж, анхдагч материалын хамт төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

34.4. Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 34.3-т заасан тайланд дурдсан нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргаж барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

34.5. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайланг доор дурдсан хугацаанд аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлнэ:

34.5.1. тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш 120 өдрийн дотор;

34.5.2. дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтийг жил бүрийн 12 дугаар сард багтаан батлагдсан маягтын дагуу;

34.5.3. тухайн жилийн үйл ажиллагааны тайлан, маркшейдерийн хэмжилтээр тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлт болон график зургийг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлагдсан маягтын дагуу.

34.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 34.5.1-д заасан техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авч барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

34.7. Энэ хуулийн 34.5.3-т заасан тайланд доор дурдсан зүйлийг тусгана:





34.7.1.ажилласан өдөр, ажиллагчийн тоо, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлтэй холбоотой гэрээ, хэлцэл;

34.7.2.уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл, нөөцийн хөдөлгөөний тооцоо, уурхай ажилласан хугацаа, үйлдвэрлэлийн дамжлагын схем, өргөтгөл, шинэтгэлийн ажил;

34.7.3.олборлосон, үйлдвэрлэсэн, ачуулсан, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, борлуулсан үнэ, түүнийг худалдан авагчийн тухай мэдээлэл, тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн болон ашиглаж байгаа тоног төхөөрөмж, бусад хөрөнгийн тухай мэдээ.

34.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 27, 28 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт болон тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

34.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 34.7.3-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн мэдээг татварын албанаас баталсан маягтын дагуу улирал тутам гаргаж дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор татварын албанд тус тус тушаана.

34.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 01 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.

34.11.Энэ хуулийн 34.5.2, 34.5.3-т заасан маягыг төрийн захиргааны байгууллагын дарга батална.

### **ДОЛООДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ДУУСГАВАР БОЛОХ**

#### **35 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл дуусгавар болох үндэслэл**

35.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл доор дурдсан тохиолдолд дуусгавар болно:

35.1.1.тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан;



35.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгсөн;

35.1.3. аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрлийг цуцалсан.

35.2. Тусгай зөвшөөрөл дуусгавар болсноор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайг хаах талаар энэ хуулийн 27, 28, 32 дугаар зүйл болон байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөгдөхгүй.

35.3. Тусгай зөвшөөрөл дуусгавар болоход түүнийг эзэмшиж байсан этгээд тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг даргад буцааж өгөх бөгөөд уг талбайд энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл шинээр олгож болно.

35.4. Хайгуулын болон уурхайн талбайд үлдээх техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга байгууламж, бусад эд хөрөнгийн өмчлөлийн асуудлыг Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

### **36 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгөх**

36.1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн захиргааны байгууллагын баталсан маягтын дагуу өргөдөл гаргаж тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг өөрийн хүсэлтээр бүхэлд нь буцаан өгч болно.

36.2. Талбайг бүхэлд нь буцаан өгөх тухай өргөдөлд байгаль орчныг хамгаалах, мэдээ, тайлан гаргах зэрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг болон энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан уурхайг хаах үед тавих шаардлагыг биелүүлсэн тухай нотлох баримтыг хавсаргана.

36.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 36.1-д заасан өргөдлийг хүлээн авсан даруйд тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 36.2-т заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, түүнийг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэж, зохих өөрчлөлт оруулна.

36.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгсний дараа тусгай зөвшөөрлийн гэрчилгээг аймаг, нийслэлийн Засаг даргад буцааж өгнө.



36.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан авсан тухай төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

36.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч талбайг бүхэлд нь буцаан өгснөөс хойш хоёр жилийн хугацаанд тус талбайд дахин өргөдөл гаргах эрхгүй.

### **37 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг цуцлах**

37.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрлийг доор дурдсан үндэслэлээр цуцална:

37.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 6.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангахгүй болсон;

37.1.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөөгүй;

37.1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөөгүй, байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага дүгнэлт гаргасан;

37.1.4.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах нэрээр өөр төрлийн ашигт малтмал хайж, ашигласан нь тогтоогдсон.

37.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 37.1.1-37.1.4-т заасан цуцлах үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 10 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрлийг цуцлах болсон үндэслэлийг тодорхой заана.

37.3.Энэ хуулийн 37.2-т заасан мэдэгдэлд заасан үндэслэлийг зөвшөөрөхгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигч түүнийгээ нотлох баримт бичгийг аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлнэ.

37.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 37.3-т заасан баримт бичгийг хянаж үндэслэлтэй бол тусгай зөвшөөрлийг цуцлах тухай мэдэгдлийг хүчингүй болгох ба үндэслэлгүй бол тусгай зөвшөөрлийг цуцалж, шийдвэрийг эзэмшигчид нь мэдэгдэнэ.



37.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэр гартал тухайн талбайд шинээр тусгай зөвшөөрөл олгохгүй.

37.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалсан бол мэргэжлийн хяналтын байгууллагад, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан бол татварын асуудал эрхэлсэн байгууллага, төрийн захиргааны байгууллагад тус тус мэдэгдэнэ.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЭЛ, ТӨЛБӨРИЙН ХУВААРИЛАЛТ, НӨХӨН ТӨЛБӨР**

#### **38 дугаар зүйл.Ашигт малтмалтай холбоотой мэдээлэл, бүртгэлтэй танилцах**

38.1.Сонирхсон этгээд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй ажлын цагаар зориулалтын байранд танилцах эрхтэй.

38.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулах бөгөөд мэдээ, тайланг хүлээлгэн өгөхдөө нууц хадгалах талаар гэрээ байгуулж болно.

38.3.Энэ хуулийн 38.2-т заасны дагуу нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн нууцын тухай<sup>9</sup>, Байгууллагын нууцын тухай<sup>10</sup>, Хувь хүний нууцын тухай хууль<sup>11</sup> заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, нийтлэх буюу нийтэд мэдээлэхийг хориглоно.

#### **39 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуваарилах**

39.1.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуваарилахтай холбогдсон харилцааг Төсвийн тухай хуулиар<sup>12</sup> зохицуулна.

#### **40 дүгээр зүйл.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын нөхөн төлбөр**

40.1.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоон ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн түгээмэл

<sup>9</sup>Төрийн нууцын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>10</sup>Байгууллагын нууцын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>11</sup>Хувь хүний нууцын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>12</sup>Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.



тархацтай ашигт малтмалын орд газарт олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу хайгуулын ажилд улсын төсвөөс гаргасан зардлыг олборлолт явуулж эхэлсэн хугацаанаас эхлэн гэрээний үндсэн дээр улсын төсөвт буцааж нөхөн төлнө.

### **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБОГДСОН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ**

#### **41 дүгээр зүйл.Талбайн хилийн маргааныг шийдвэрлэх**

41.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд үүссэн талбайн хилийн маргааныг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

41.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга маргагч талуудад өөрсдийн байр суурийг бичгээр илэрхийлэх болон үндэслэлээ харилцан тайлбарлах бололцоо олгоно.

41.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд тусгагдсан маргаантай талбай хоорондоо ямар нэг байдлаар давхцаж байгаа эсэхийг шалгах бөгөөд давхцал байгаа нь тогтоогдвол тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн анхны өргөдөл болон талбайн хилийн хэмжилтийн тайланг үндэслэн талбайн хил, булангийн цэгийн солбицлууд зөв бүртгэгдсэн эсэхийг шалгана.

41.4.Хэмжилтийн дүнд давхцал байгаа нь тогтоогдвол аймаг, нийслэлийн Засаг дарга сүүлд авсан тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд зохих өөрчлөлтийг оруулж, давхцалыг арилгана.

41.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайн маргаантай хилийг төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан этгээдээр хэмжүүлж тогтоолгох бөгөөд үүнтэй холбогдон гарсан зардлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

41.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь маргаантай хил, цэгийн солбицлуудыг шалгаж, холбогдох засвар, өөрчлөлтийг хийсэн тухай шийдвэр гаргаж, энэ тухай маргаанд оролцогч талуудад мэдэгдэнэ.

41.7.Маргаанд оролцогч тал аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.



**42 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэх**

42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хооронд тухайн газарт нэвтрэн орох, дамжин өнгөрөх, ашиглах талаар гарсан маргааныг шүүх Иргэний хууль, Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

**43 дугаар зүйл.Төрийн байгууллагад гомдол гаргах**

43.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн талаар холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно.

**АРАВДУГААР БҮЛЭГ  
ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ**

**44 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

44.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол геологи, уул уурхайн улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд доор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

44.1.1.тусгай зөвшөөрөлгүй этгээд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийсэн, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон, борлуулсан, ашигт малтмалын орд ашигласан бол хууль бусаар олсон орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж, уг этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.2.энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс хоёр дахин дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин



нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.4.энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг биелүүлээгүй хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

44.1.5.ашигт малтмал хайх, ашиглах ажиллагааны явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар геологи, уул уурхайн улсын байцаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй бол албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.6.хяналт шалгалт явуулж байгаа эрх бүхий албан тушаалтанд үүргээ гүйцэтгэхэд нь санаатайгаар саад учруулсан этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

44.2.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, уул уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг хоёр удаа зөрчсөн бол эрх бүхий улсын байцаагч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааг хоёр сарын хугацаагаар зогсоох бөгөөд энэ хугацаанд зөрчлийг засаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу цуцлах тухай асуудлыг тухайн тусгай зөвшөөрлийн талбай оршиж байгаа аймаг, нийслэлийн Засаг даргад тавина.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.19, 11.1.20 дахь заалтын “цацраг идэвхт” гэсний дараа “болон түгээмэл тархацтай” гэж тус тус нэмсүгэй.



**2 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“32.3.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон уурхайн талбайн гектар тутамд 15 америк доллар байх бөгөөд харин шохойн чулуу, нүүрс, дотоодын үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын хувьд гектар тутамд 5 америк доллар байна.”

**3 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 47<sup>1</sup> зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.2.7 дахь заалт нэмсүгэй:

“16.2.7.түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 35.6 дахь хэсэг нэмсүгэй:

“35.6.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь доор дурдсан төлбөр төлнө:

35.6.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 100 төгрөг, хоёр дахь жилд 200 төгрөг, гурав дахь жилд 300 төгрөг, дөрвөөс тав дахь жилд тус бүр 1000 төгрөг;

35.6.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн 0-20 гектар тутамд 5000 төгрөг, 30 гектар хүртэл 8000 төгрөг, 50 гектар хүртэл 10000 төгрөг, 100 гектар хүртэл 15000 төгрөг, 200 гектараас дээш 20000 төгрөг.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан аймаг, нийслэлийн Иргэний зөвлөлийн таваас долоон гишүүнийг анх томилохдоо таван гишүүнтэй байх бол нэг гишүүн нь нэг жил, хоёр гишүүн нь хоёр жил, хоёр гишүүн нь гурван жил, долоон гишүүнтэй байх



бол нэг гишүүн нь нэг жил, гурван гишүүн нь хоёр жил, гурван гишүүн нь гурван жилийн хугацаатай байхаар тус тус томилно.

**2 дугаар зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 19.5-д заасан жишиг стандарт, 20.1.3-т заасан эрх зүйн актыг баталж, мөрдүүлэх хүртэл хугацаанд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.**Цагдаагийн албаны тухай хуульд заасан цагдаагийн байгууллагад дотоодын цэргийн бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаах үйл ажиллагаатай холбоотой төсөв, санхүү, дэд бүтэц, барилга байгууламж, материал техникийн хангамж, зэвсэг хэрэгслийг шилжүүлэх ажлыг 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**4 дүгээр зүйл.**Дотоодын цэргийн алба хаагч цагдаагийн албанд шилжсэн үеэс Цагдаагийн албаны тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Алба хаагчдыг цагдаагийн мэргэжлийн сургалтад хамруулж, хувцас, агсамжаар хангах ажлыг цагдаагийн төв байгууллагын дарга хариуцан гүйцэтгэнэ.

**5 дугаар зүйл.**Цагдаагийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө цагдаагийн болон дотоодын цэргийн байгууллагад ажиллаж байсан алба хаагч, ажилтны цалин хөлс, хангамжийн нөхцөлийг дордуулахгүй байх арга хэмжээг Засгийн газар авна.

**6 дугаар зүйл.**1993 оны 12 дугаар сарын 02-ны өдөр баталсан Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь заалтад заасан тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийх, ашиглах журмын биелэлтэд хяналт тавих цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх захиргааны үүргийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт шилжүүлэх хүртэл хугацаанд цагдаагийн байгууллага үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

**7 дугаар зүйл.**1993 оны 12 дугаар сарын 02-ны өдөр баталсан Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулиар олгосон цолны тэмдгийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зөвхөн цагдаагийн алба хаагчийн ёслолын хувцсанд зүүж хэрэглэнэ. Ёслолын хувцсыг өдөр тутам болон албан хэрэгцээнд өмсөж хэрэглэхийг хориглоно.

**8 дугаар зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 20.1.15-д заасан “мөрдөгч” гэсэн нэр томъёонд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан “хэрэг бүртгэгч”, “мөрдөн байцаагч” тус тус хамаарна.



**9 дүгээр зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 9.1, 13.4.2, 13.8, 16.1.2, 22.1.1, 23.2, 40.4-т заасан “мөрдөн шалгах” гэснийг “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт” гэж, мөн хуулийн 9.2.4, 40.3-т заасан “мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэснийг “гүйцэтгэх ажил” гэж, мөн хуулийн 13.9, 23.2, 40.4-т заасан “холбогдох хууль” гэснийг “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”, 26.3-т заасан “холбогдох хууль” гэснийг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” гэж, 41.2-т заасан “холбогдох хуульд” гэснийг “Захиргааны хариуцлагын тухай болон Эрүүгийн хуульд” гэж тус тус ойлгоно.

**10 дугаар зүйл.**Цагдаагийн алба хаагч зөвхөн дүрэмт хувцастай үүрэг гүйцэтгэх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих болсонтой холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжид төрөөс олгодог нөхөн олговрын цагдаагийн алба хаагчид холбогдох хэсгийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зогсоож, Төрийн албаны тухай хуулийн 27.1.3-т заасны дагуу ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлыг цагдаагийн алба хаагчид нөхөн олгоно.

**11 дүгээр зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 39.2-т заасан урамшлыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй 60 буюу түүнээс дээш сарын хугацаагаар ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид нэг удаа 2014 онд олгох бөгөөд 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа хугацаа нь 60 сар хүрээгүй цагдаагийн алба хаагчид урьд тасралтгүй ажилласан жилийг оруулан тооцож 2015 оноос эхлэн олгоно.

**12 дугаар зүйл.**Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан урамшлыг олгохдоо цагдаагийн алба хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээгээр тогтоосон зэрэглэл, шатлалын дагуу тооцно.

**13 дугаар зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7.1.6-д заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хуульд заасны дагуу баривчлахаар шилжүүлсэн хүмүүсийг хүлээн авч, холбогдох шийдвэрийг биелүүлэх үүргийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд цагдаагийн байгууллага үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Баривчлах шийдвэр биелүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн, баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн тус тус хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**14 дүгээр зүйл.**Хорих ял эдлээд суллагдсан, тэнсэн харгалзсан, ял эдлүүлэхийг хойшлуулсан зарим хүнд тавих захиргааны хяналтыг



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталж, мөрдөх хүртэл хугацаанд цагдаагийн байгууллага үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

**15 дугаар зүйл.** Тахарын албаны тухай хуульд заасан шүүхийн аюулгүй байдлыг хариуцах алба, нэгж байгуулагдах хүртэл хугацаанд шүүхийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг цагдаагийн байгууллага үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

**16 дугаар зүйл.** Хууль сахиулагч албаны үүргээ гүйцэтгэх үедээ биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх харилцааг зохицуулах холбогдох хууль батлагдаж, хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд цагдаагийн байгууллага, алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн 33.6-д заасан биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ энэ хуулийн 17-21 дүгээр зүйлд заасныг баримтална.

### **17 дугаар зүйл.**

17.1. Цагдаагийн байгууллага, алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхэд дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

17.1.1. боллоцроотой бүх тохиолдолд галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх тухайгаа урьдчилан сануулах;

17.1.2. тухайн нөхцөл байдалд хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх;

17.1.3. хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол эмнэлгийн байгууллагад мэдэгдэж, эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэн шууд захирах даргадаа, шууд захирах дарга нь прокурорт мэдэгдэх.

17.2. Цагдаагийн байгууллагад ашиглах галт зэвсэг, тусгай хэрэгслийн жагсаалт, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална.

17.3. Төрийн тусгай албанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага, түүнчлэн иргэн цагдаагийн төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр галт зэвсэг, тусгай хэрэгслийг үйлдвэрлэх, дуурайлган хийх, гадаадаас оруулж ирэх, олж авах, борлуулахыг хориглоно.

17.4. Албаны зориулалтаар шинээр галт зэвсэг, тусгай хэрэгслийг худалдан авах, албан хэрэгцээнд оруулахаас өмнө хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан танилцуулж, зөвшөөрөл авна.



17.5.Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр албан хэрэгцээнд хүлээн авч бүртгэсэн тусгай хэрэгслийг цагдаагийн байгууллагад хэрэглэнэ.

17.6.Цаг хугацаа, нөхцөл байдлын хувьд хууль тогтоомжид заасан журмыг хэрэгжүүлэх боломжгүй, эсхүл өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд аюул тулгарсан тохиолдолд цагдаагийн алба хаагч тусгай хэрэгсэл, галт зэвсгийг шууд сонгон хэрэглэж болно.

17.7.Цагдаагийн алба хаагч хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй.

**18 дугаар зүйл.**Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ биеийн хүч хэрэглэж болох бөгөөд хүч хэрэглэхгүйгээр үүргээ гүйцэтгэх боломжтой тохиолдолд биеийн хүч хэрэглэхгүй.

### **19 дүгээр зүйл.**

19.1.Цагдаагийн байгууллага, алба хаагч тусгай хэрэгслийг дараах үндэслэлээр хэрэглэнэ:

19.1.1.хүний амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулыг таслан зогсоох;

19.1.2.гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэж байгаа этгээдийн үйлдлийг таслан зогсоох, баривчлах;

19.1.3.зэвсэглэсэн болон эсэргүүцэл үзүүлж болзошгүй этгээдийг баривчлах;

19.1.4.баривчлагдсан этгээдийг цагдаагийн байгууллага, төрийн бусад байгууллагад хүргэх, сэжигтэн, яллагдагчийг хуяглан хүргэх;

19.1.5.гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдсон этгээд болон цагдаагийн байгууллагын хяналтад байгаа иргэн амиа хорлохоос урьдчилан сэргийлэх зорилгоор;

19.1.6.сэтгэцийн эмгэг, санаа сэтгэл хүчтэй цочрон давчидсаны улмаас өөрийгөө удирдах чадвараа алдсан, түүнчлэн согтууруулах, мансууруулах, хордуулах бодис хэрэглэсэн, эсхүл бусад этгээд догшин, хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаар бол;



19.1.7.олон нийтийн арга хэмжээний үед нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй бол;

19.1.8.нийтийн эмх замбараагүй байдал, нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох, хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг биелүүлэх;

19.1.9.бусдын албаны болон орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;

19.1.10.гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагааны үед оргон зайлах, дахин гэмт хэрэг үйлдэх, амиа хорлохоос урьдчилан сэргийлэх;

19.1.11.тээврийн хэрэгслийг зогсоох цагдаагийн алба хаагчийн шаардлагыг үл биелүүлэн зугтаасан бол;

19.1.12.энэ хуулийн 19.8-д заасан үндэслэл бий болсон бол.

19.2.Энэ хуулийн 19.1.4, 19.1.5-д заасан тохиолдолд энэ хуулийн 19.5.1, 19.5.2, 19.5.7-д заасан тусгай хэрэгслийг хэрэглэж болох бөгөөд энэ хуулийн 19.1.11-д заасан тохиолдолд тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл, тээврийн хэрэгсэл болон бусад зүйлээр хаалт тавьж болно.

19.3.Цагдаагийн байгууллага, алба хаагч хуульд заасан үүргээ гүйцэтгэхдээ дараах тусгай хэрэгсэл хэрэглэнэ:

19.3.1.олон хүнд нөлөөлөх;

19.3.2.нэг бүрийн;

19.3.3.бусад.

19.4.Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэх ба үүнд дараах хэрэгсэл хамаарна:

19.4.1.олон хүнд нэгэн зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч;

19.4.2.усан хөөрөг;



- 19.4.3.утаан хөшиг үүсгэгч;
- 19.4.4.олон хүнд нөлөөлөх бусад тусгай хэрэгсэл.

19.5.Нэг хүнд нөлөөлөх хэрэгслийг нэг бүрийн тусгай хэрэгсэл гэх ба үүнд дараах хэрэгсэл хамаарна:

- 19.5.1.гар, хөл, хурууны гав;
- 19.5.2.хүлэг, ороох цамц;
- 19.5.3.резинэн бороохой;
- 19.5.4.цахилгаан гүйдлээр цохигч;
- 19.5.5.нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;

- 19.5.6.резинэн ба хуванцар сумтай буу;
- 19.5.7.нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.

19.6.Цагдаагийн байгууллага нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар, уснаа явагч зэрэг тээврийн хэрэгсэл болон тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, эвдэгч, галт хэрэглэл, гэрэл, дууны хэрэгсэл, тусгай будагч, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгагч, тээврийн хэрэгслийн хурд хэмжигч, албаны нохой зэрэг бусад тусгай хэрэгсэл ашиглах эрхтэй.

19.7.Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх албан хаагчид галт зэвсэг олгож болно.

19.8.Цагдаагийн алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг бие даан гаргана.

19.9.Түр саатуулах байргүй газарт гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, саатуулагдсан этгээдийг энэ хуулийн 19.5.1, 19.5.2, 19.5.7-д заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэн тусгаарлаж болно.

19.10.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг цагдаагийн байгууллагын дарга, түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан гаргаж доор дурдсан журмаар хэрэгжүүлнэ:

19.10.1.шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараалал, эхлэх, дуусгах шийдвэрийг гаргах;

19.10.2.цагдаагийн алба хаагчийг хамгаалах тусгай хэрэгслээр хангах;



19.10.3.цаг хугацааны хувьд боломжтой бол прокурорт урьдчилан мэдэгдэх;

19.10.4.эмнэлгийн болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэх;

19.10.5.уг хэрэгслийн нөлөөлөх бүсэд байгаа жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй этгээдийг тухайн бүсээс холдох талаар тусгай хэрэгсэл хэрэглэхээс өмнө анхааруулах;

19.10.6.боломжтой бол тухайн тусгай хэрэгслийн үйлчлэх нөлөөллийн талаар анхааруулах.

19.11.Олон хүнд зэрэг нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа энэ хуулийн 19.10-т заасан албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авна:

19.11.1.хордсон хүн, амьтан, тэсэрч дэлбэрэх бодис, гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээ авах;

19.11.2.шаардлагатай хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авах;

19.11.3.тухайн орчныг ариутгах, цэвэршүүлэх арга хэмжээ авах талаар холбогдох байгууллагад мэдэгдэх;

19.11.4.тусгай хэрэгслийн үйлчлэх чадвар дуусах хүртэл тухайн орчинд харуул хамгаалалт гаргаж, иргэдэд зөвлөгөө, сануулга өгөх.

19.12.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн үндэслэл, явц, үр дүн, хүний эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авсан тухай дэлгэрэнгүй илтгэх хуудсыг нэн даруй бичиж шууд захирах даргад, шууд захирах дарга нь дээд шатны байгууллагын даргад танилцуулна.

## **20 дугаар зүйл.**

20.1.Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэх эрхтэй:

20.1.1.цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон, тээврийн хэрэгсэл унаж зугтаан орчиндоо аюул бий болгосон;





20.1.2.галт зэвсгийг нь булаахаар довтолсон;

20.1.3.цагдаагийн хамгаалалтад байгаа бүс, объект руу хууль бусаар зэвсэг хэрэглэн нэвтрэн орсон, эсхүл бүлэглэн довтолсон;

20.1.4.барьцаанд байгаа хүнийг суллах;

20.1.5.хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, онц аюултай гэмт хэрэгтэн болон сэрдэгдсэн этгээд оргон зугтсан бөгөөд түүнийг баривчлах үед хүч хэрэглэн эсэргүүцсэн;

20.1.6.галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;

20.1.7.хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн довтолсон, эсхүл бүлэглэн довтолсон;

20.1.8.баривчлах, саатуулах, хорих, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүсч хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах нөхцөл байдал бий болсон;

20.1.9.бусдын албаны болон орон байр руу зэвсэглэн, бүлэглэн довтолсон этгээдийн дайралтыг таслан зогсоох, эзлэн авсныг чөлөөлөх;

20.1.10.нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед галт зэвсэг хэрэглэн довтолсон, хамгаалсан, хориглосон этгээдэд;

20.1.11.иргэдийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор уршиг учруулж болзошгүй болон учруулж байгаа амьтныг устгахад;

20.1.12.анхааруулга, түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах;

20.1.13.бэлтгэл, сургуулилтын үед.

20.2.Цагдаагийн алба хаагч галт зэвсгийг дараах журмын дагуу хэрэглэнэ:

20.2.1.энэ хуулийн 20.1.1-20.1.10-т заасан тохиолдол бий болсон үед галт зэвсгээ бэлэн байдалд авах;



20.2.2. тухайн этгээдэд галт зэвсэг хэрэглэх тухай сануулах, тодорхой зай байрлал тогтоох, хууль бус үйлдлээ зогсоохыг шаардах, эсхүл идэвхтэй үйлдэл хийхийг хориглох;

20.2.3. энэ хуулийн 20.2.2-т заасны дагуу сануулсны дараа тухайн этгээд үйлдлээ үргэлжлүүлсэн тохиолдолд галт зэвсэг хэрэглэх.

20.3. Галт зэвсэг хэрэглэсний улмаас хүн гэмтсэн тохиолдолд эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх арга хэмжээ авч эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

20.4. Галт зэвсэг хэрэглэсний улмаас хүн нас барсан тохиолдолд прокурор, эрх бүхий албан тушаалтан ирэх хүртэл цогцос, хэргийн газрыг хамгаалалтад авна.

20.5. Цагдаагийн алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн үндэслэл, хүний биед учирсан гэмтэл, үзүүлсэн тусламж, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдсэн тухай шууд захирах даргадаа нэн даруй танилцуулж, бичгээр тайлбар үйлдэх бөгөөд шууд захирах дарга нь прокурорт мэдэгдэнэ.

## **21 дүгээр зүйл.**

21.1. Хүний амь насанд аюултайгаар зэвсэглэн эсэргүүцсэн, довтолсон, бүлэглэн дайрнаас бусад тохиолдолд жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй болох нь тодорхой, эсхүл бие махбодийн хөгжлийн бэрхшээлтэй нь илт мэдэгдэж байгаа этгээдэд тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхийг хориглоно.

21.2. Хүний амь насанд аюултайгаар зэвсэглэн эсэргүүцсэн, довтолсон, бүлэглэн дайрсан, эсхүл амиа хорлож болзошгүйгээс бусад тохиолдолд жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй болох нь тодорхой, эсхүл бие махбодийн хөгжлийн бэрхшээлтэй нь илт мэдэгдэж байгаа этгээдэд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.

21.3. Тухайн этгээд аюулгүй болсон тохиолдолд цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно.

**22 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийн “байгууллагын” гэсний дараа “дэмжлэг үзүүлэх нэгжийн” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### “18 дугаар зүйл.Цагдаагийн байгууллагын удирдлага

18.1.Цагдаагийн төв байгууллагын даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.

18.2.Цагдаагийн төв байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн тэргүүн дэд дарга, дэмжлэг үзүүлэх асуудал эрхэлсэн дэд даргатай байна.

18.3.Дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хариуцсан нэгжийн дарга нь цагдаагийн төв байгууллагын дэд дарга байна.

18.4.Энэ хуулийн 18.2, 18.3-т заасан тэргүүн дэд дарга, дэд даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

18.5.Цагдаагийн төв байгууллагын даргын дэргэд түүний эрх хэмжээнд хамаарах асуудлаар зөвлөх эрх бүхий орон тооны бус зөвлөл ажиллана. Зөвлөлийн дүрмийг цагдаагийн төв байгууллагын дарга батална.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1995 оны 10 дугаар сарын 17-ны өдөр баталсан Дотоодын цэргийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, мөн зүйлийн 28.6.3 дахь заалтын “ба дотоодын” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “, дотоодын” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “, дотоодын”, “болон дотоодын” гэснийг тус тус хассугай.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Дотоодын цэргийн” гэснийг “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР,  
ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “болон дотоодын” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.**Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН  
ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН  
ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийн “, Дотоодын цэргийн штаб” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД  
ОРОЛЦОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “ба дотоодын” гэснийг тус тус хассугай.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Онц байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “цагдаа, дотоодын цэргийн” гэснийг “цагдаагийн байгууллагын” гэж, 3 дахь хэсгийн “цагдаа, дотоодын цэрэгт” гэснийг “цагдаагийн байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “дотоодын цэрэг” гэснийг “цагдаагийн байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “Дотоодын цэргийн<sup>8</sup> тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасны дагуу дотоодын цэрэг” гэснийг “цагдаагийн байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “дотоодын цэрэг,” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2 дахь хэсгийн “дотоодын цэргийн” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Терроризмтой тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах



эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “болон дотоодын” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.4 дэх заалтын “дотоодын цэрэг,” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “ба дотоодын” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтын “байгууллага, дотоодын цэргийн” гэснийг “байгууллагын” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

**1/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:**

“8.3.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”

**2/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:**

“20.2.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”

**3/166<sup>2</sup>, 166<sup>3</sup> дугаар зүйл:**

**“166<sup>2</sup> дугаар зүйл.**Дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж арилжаанд оролцох

166<sup>2</sup>.1.Үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг шунахай сэдэлтээр ашиглаж үнэт



цаасыг худалдсан, худалдан авсан, эсхүл дотоод мэдээллийг бусдад дамжуулсны улмаас хөрөнгө оруулагчид их хэмжээний хохирол учруулсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>2</sup>.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасаж, найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### **166<sup>3</sup> дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах**

166<sup>3</sup>.1.Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглаж бусдад их хэмжээний хохирол учруулсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>3</sup>.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасаж, найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**2 дугаар зүйл.**Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/166<sup>1</sup> дүгээр зүйл:**

#### **“166<sup>1</sup> дүгээр зүйл. Мөнгө угаах**

166<sup>1</sup>.1.Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй



тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>1.2</sup>.Энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>1.3</sup>.Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

### **2/178<sup>2</sup> дугаар зүйл:**

#### **“178<sup>2</sup> дугаар зүйл.Терроризмыг санхүүжүүлэх**

178<sup>2.1</sup>.Террорист хүн, террорист байгууллага болон террорист ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд болон шууд бусаар, хууль бусаар болон санаатайгаар, бүхэлд нь болон хэсэгчлэн эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

178<sup>2.2</sup>.Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

**3 дугаар зүйл.**Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “зөвхөн” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2014 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 134.11 дэх хэсэг нэмсүгэй:

“134.11. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг битүүмжлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг эзэмшигч нь тодорхойгүй, эсхүл эзэмшигчид мэдэгдэх нь тус үйл ажиллагааны зорилгод хор хохирол учруулахаар бол эзэмшигч, өмчлөгчид урьдчилан мэдэгдэхгүй байж болно.”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“134.1. Иргэний нэхэмжлэл болон эд хөрөнгө хурааж болзошгүй явдлыг хангах зорилгоор яллагдагч, сэжигтэн, эсхүл хуулиар тэдний өмнөөс эд хөрөнгийн хариуцлага хүлээвэл зохих хүний эд хөрөнгийг битүүмжлэх, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг нотлох хангалттай үндэслэл байгаа бол уг хөрөнгө, орлогыг битүүмжлэх үүрэгтэй.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ОРЛОГЫГ НЬ ТУХАЙ БҮР ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУВИАРАА ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын



тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 13 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС  
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээний хүрээнд стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, үрийн шинэчлэл хийхэд шаардагдах 100.0 /нэг зуун/ мянга хүртэл тонн хүнсний улаан буудайг, 20.0 /хорин/ мянга хүртэл тонн хүнсний улаан буудайн үрийг импортлоход гаалийн албан татвараас тус тус чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн 2014 оны 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН  
ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээний хүрээнд стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, үрийн шинэчлэл хийхэд шаардагдах 100.0 /нэг зуун/ мянга хүртэл тонн хүнсний улаан буудайг, 20.0 /хорин/ мянга хүртэл



тонн хүнсний улаан буудайн үрийг импортлоход нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн 2014 оны 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 01 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалт:**

“10.1.10.ашигт малтмал хайх, ашиглах, боловсруулах, борлуулах үйл ажиллагаанд ил тод байдлыг бүрдүүлэх.”

#### **2/35 дугаар зүйлийн 35.6. дахь хэсэг:**

“35.6.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, бичил уурхайгаас алт олборлогч нь олборлосон алтаа тухайн санхүүгийн жилдээ багтааж тушаана.”

#### **3/47 дугаар зүйлийн 47.3.3 дахь заалт:**

“47.3.3.Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд энэ хуулийн 47.3.2-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2,5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.”

**2 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2 дахь заалтын “47.3.1-д зааснаас бусад” гэснийг “47.3.1, 47.3.3-т заасан Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтнаас бусад” гэж өөрчилсүгэй.





**3 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.3 дахь заалтыг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хот

### **Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай**

Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын зарчим, зорилтод нийцүүлэн эрдэс баялгийн салбарын холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулан хэрэгжүүлэх;

2/“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-д тусгасан зорилт, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, төрийн мөнгөний бодлого, дунд, урт хугацааны төлөвлөлтөд тусгуулан хэрэгжүүлэх.

3.“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



Монгол Улсын Их Хурлын 2014 оны  
18 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ  
БАРИМТЛАХ БОДЛОГО  
/2014-2025 он/**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ.

1.2.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.

1.3.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг бусад салбарын бодлоготой харилцан уялдуулан хөгжүүлнэ.

1.4.Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэх бөгөөд тэдгээр нь эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, төсөлд тусгагдан хэрэгжинэ.

**Хоёр.Эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим**

2.1.Эрдэс баялгийн салбарын хөгжлийн хэтийн төлөв, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт тулгуурлан эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг иргэдэд хүртээмжтэй байлгах зорилгоор эрдэс баялгийн салбарт баримтлах үндсэн зарчмыг дараах байдлаар тодорхойлно:

2.1.1.эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор эрх зүй, татварын орчны талаар аливаа шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээнд суурилж, оролцогч талуудын хууль ёсны эрх ашгийг хохироохгүй байх;

2.1.2.олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих;



2.1.3.эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх;

2.1.4.эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулагч нь хууль дээдлэх, харилцан ашигтай ажиллах, компанийн сайн засаглалыг дэмжих;

2.1.5.эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төрөөс хөрөнгө оруулагчдад ижил тэнцүү нөхцөл олгож, өмчийн хэлбэрээр ялгаварлахгүй байх;

2.1.6.улсын болон хувийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байгаа бүх шатны геологийн судалгаа, олборлолт, боловсруулалтын ажлын талаарх хуулиар хориглоогүй мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй байлгах;

2.1.7.эрдэс баялгийн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, стандартыг олон улсын түвшинд хүргэж, хэрэгжилтийг хангах;

2.1.8.төрийн зохицуулалтыг бүртгэл, зөвшөөрөл, хяналтын түвшинд төгөлдөржүүлж, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд оролцохыг зохистой түвшинд байлгах.

### **Гурав.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын чиглэл**

#### **3.1.Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд:**

3.1.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын хайгуул, ашиглалтын эрх зүйн орчныг тусгайлан бүрдүүлэх;

3.1.2.бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг төрөөс бодлогоор дэмжиж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

3.1.3.ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг шилжүүлэх /аж ахуйн нэгжийг болон компанийн хяналтын хувьцааг худалдан авах/-тэй холбоотой бүртгэл, хяналтыг боловсронгуй болгох;

3.1.4.алтны олборлолт, худалдаанд тавих хяналтыг чангатгах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох;



3.1.5.дэлхийн эдийн засаг, бүс нутгийн зах зээлийн төлөв байдал, цаашдын чиг хандлагад судалгаа, шинжилгээ тогтмол хийж, дотоодын эрдэс баялгийн бүтээгдэхүүний олборлолт, ашиглалт, нөөц бүрдүүлэх чиглэлээр урт, дунд, богино хугацааны хөтөлбөр боловсруулж, мөрдөн ажиллах;

3.1.6.Монгол Улсын геологийн тогтоцын ялгагдах онцлог байдал, дахин давтагдашгүй онцгой тогтоц, давхарга зүйн тулгуур зүсэлт, эрдэс чулуулгийн ховор олдвор, дээжийг улсын хамгаалалтад авч хадгалах эрх зүйн орчныг бүрдүүлж, үндэсний геопарк байгуулах;

3.1.7.ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлэх;

3.1.8.эрдэс баялгийн салбарын судалгааны ажлыг мэргэшсэн инженерийн баг бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.9.эрдэс баялгийн болон ашигт малтмалын ордын нөөцийг үнэлэх олон улсын стандартад шилжих;

3.1.10.улсын болон бүс нутгийн хөгжилд нөлөө бүхий ашигт малтмалын ордыг нэгдмэл байдлаар ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.11.эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн эрх, үүргийг нь мэргэжлийн холбоод, мэргэшсэн шинжээчдэд шилжүүлэх;

3.1.12.маргаан шийдвэрлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн хуульч, эдийн засагч, шинжээч, арбитрчийг бэлтгэх.

## **3.2.Геологийн салбарын хүрээнд:**

3.2.1.Улсын эрдэс баялгийн санг тасралтгүй нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1.1.уул уурхайн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор геологи хайгуулын салбарыг түрүүлэн хөгжүүлэх бодлого баримтлах;

3.2.1.2.Монгол Улсын ой, усны нөөцийн байршил, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төвлөрөл, тархалт, ашигт малтмалын орд,



уурхайн байршлыг харгалзан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг боловсронгуй болгож, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх геологийн эрэл, хайгуулын ажлыг төрөөс зөвшөөрсөн газар нутагт гүйцэтгэх, энэ чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оруулах;

3.2.1.3. эрдэс баялгийн хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулж геологийн зураглал, эрэл, хайгуулын ажлыг нэмэгдүүлэх;

3.2.1.4. орчин үеийн шинэ техник, технологийн түүхий эд, материалын геологийн судалгааг төрөөс дэмжих.

3.2.2. Геологийн судалгаа, хайгуулын ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд:

3.2.2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, бүтэц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг тогтоохоор улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэдэг геологийн шинжлэх ухааны ажил, сэдэвчилсэн судалгаа, зураглал, эрлийн ажилд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг татан оруулах, энэ төрлийн ажлыг хувийн хөрөнгөөр гүйцэтгэхийг бодлогоор дэмжих;

3.2.2.2. геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизикийн ажлын хэмжээ болон улсын төсвийн санхүүжилтийг жил бүр тогтвортой өсгөж Монгол орны геологийн судалгааны хамрах хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах;

3.2.2.3. улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд геофизик, геохими, уул-өрөмдлөгийн ажлыг цогцоор нь гүйцэтгэж чанарыг сайжруулах, хүдрийн дүүрэг, илрэл бүхий талбайд зарим онцгой тохиолдолд нарийвчилсан судалгааг гүйцэтгэх;

3.2.2.4. улсын хэмжээний геоэкологийн нэгдсэн судалгааг эрчимжүүлж, тодорхой хот, аймаг болон сумдын хэмжээнд геоэкологийн төрөлжсөн судалгааг гүйцэтгэх;

3.2.2.5. геологийн судалгааг мэргэшсэн инженер, техникийн ажилтнаас бүрдсэн багийн мэдлэг, туршлагад түшиглэж, нутаг дэвсгэрийн геологийн тогтоцын онцлогт тохирсон оновчтой арга, аргачлал, дэвшилтэт техник, технологиор гүйцэтгүүлж, геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх;



3.2.2.6.Монгол Улсад гүйцэтгэж байгаа төрөл бүрийн геологийн судалгаа /байгалийн рашаан, гидрогеологийн судалгаа, байгалийн хий, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, инженер геологи гэх мэт/-ны мэдээлэл, нөөц, үр дүнгийн тайланг үндэсний геомэдээллийн нэгдсэн санд хамруулж улсын бүртгэлд авах;

3.2.2.7.гадаад орнуудтай геологийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтарсан, үр ашигтай судалгааны төсөлд хувийн хэвшлийн оролцоог дэмжих;

3.2.2.8.Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөнийг жил бүр хийж, бүртгэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;

3.2.2.9.геологи, эрдэс баялгийн судалгааны ажлын тайлан, үр дүнг олон улсын жишиг, стандартад нийцсэн аргачлал, нөөцийн ангиллын дагуу нэгтгэн боловсруулж, үндэсний геомэдээллийн нэгдсэн санг иж бүрнээр бүрдүүлэн баяжуулах;

3.2.2.10.үндэсний геомэдээллийн нэгдсэн санг цахим мэдээллийн технологийн системд шилжүүлж, геологи, хайгуулын ажлын тайлан, анхдагч баримт материал болон дээж, чулуулгийн сорьц хадгалах, архивлах шинэчилсэн заавар, стандартыг бий болгох;

3.2.2.11.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайг олон улсын жишигт нийцүүлэн кадастрын нэгж талбарын зарчимд шилжүүлэх бодлого баримтлах.

### **3.3.Олборлох салбарын хүрээнд:**

3.3.1.Монгол Улсын хөгжлийн цаашдын чиг хандлагатай уялдуулсан орчин үеийн, олон улсын стандартад нийцсэн, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, экспортын чиг хандлагатай, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангасан, ил тод, хариуцлагатай уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлах;

3.3.2.Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод төрийн хяналт, зохицуулалт, хариуцлагыг дээшлүүлэх замаар үйл ажиллагаа, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг боловсронгуй болгох;

3.3.3.хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашиглаж ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжих;



3.3.4.олборлолт, боловсруулалтын хэмжээг улс орны эдийн засаг, аж үйлдвэржилтийн нөхцөл байдал, гадаад, дотоод зах зээлийн цаашдын хэтийн төлөвтэй уялдуулан оновчтой төлөвлөх;

3.3.5.уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд төр, орон нутгийн зүгээс тавих хяналт, төлбөр, хураамж ногдуулалтыг хүнд суртал, давхардалгүй болгох;

3.3.6.эрдсийн гаралтай импортын бараа, материалыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;

3.3.7.уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөн нэмэгдүүлэх зорилгоор олборлох салбарт шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

#### **3.4.Боловсруулах салбарын хүрээнд:**

3.4.1.боловсруулах салбарыг хөгжүүлэхдээ зах зээл дэх өрсөлдөх чадвар, үйлдвэрлэлд зарцуулагдах усны хэрэглээ болон үйлдвэрлэлээс гарах хорт хаягдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэрэг хүчин зүйлийг цогцоор нь судалж, шийдвэр гаргах;

3.4.2.боловсруулах салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3.4.3.эрдэс баялгийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг бодлогоор дэмжих;

3.4.4.нүүрс баяжуулах, кокс, химийн үйлдвэр байгуулах, нүүрсний ордод түшиглэсэн цахилгаан станц барих, хүрэн нүүрснээс утаагүй, шингэн түлш, хий, шатдаг занараас шингэн түлш гарган авах зэрэг төслийг дэмжих;

3.4.5.төрөөс боловсруулах үйлдвэрийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжиж, ашигт малтмалын боловсруулалтын түвшинг дээшлүүлэх.

#### **3.5.Орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд:**

3.5.1.тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө хөрөнгө оруулагч, орон нутгийн иргэдийн хоорондын харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн төслийн нийгэм,



эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажилд орон нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;

3.5.2.уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулах.

### **3.6.Байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд:**

3.6.1.олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн үе шатуудад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрт байдлыг хангасан байх;

3.6.2.төрийн өмчийн аж ахуйн нэгж нь ерөнхий гэрээлэгчийн зарчмаар ажиллаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг хэрэгжүүлэх;

3.6.3.уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах;

3.6.4.эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний цэнгэг усыг аль болох ашиглахгүй байх, гадаргын усыг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усыг дахин ашиглах, уул уурхайн салбарын ахуйн хэрэглээнд саарал усыг ашиглах, орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих;

3.6.5.олборлох, боловсруулах үйлдвэрийн хаягдлыг дахин боловсруулахад хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, үр ашигтай техник, технологи хэрэглэхийг дэмжих.

### **3.7.Эрдэс баялгийн салбарын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн хүрээнд:**

3.7.1.төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх зорилго, чиг үүрэг бүхий төрийн байгууллага, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тэгш байдлыг хангасан Бодлогын зөвлөлийг байгуулж, ажиллуулах;

3.7.2.төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх;





3.7.3.төрийн өмчийн аж ахуйн нэгжийн удирдлага, менежментийг сонгон шалгаруулахдаа компанийн сайн засаглалын зарчмыг баримтлах;

3.7.4.эрдэс баялгийн салбарын үйлдвэрлэлээс улсын төсөвт төвлөрсөн орлогын тодорхой хэсгээр зорилтот сангуудыг үүсгэх замаар эдийн засгийг төрөлжүүлэн тогтвортой байдлыг хангах, экспортын чиглэлийн үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд зарцуулах;

3.7.5.эрдэс баялгийн бүтээгдэхүүний гадаад, дотоодын зах зээл дээрх борлуулалтыг нээлттэй, оновчтой, өндөр үр ашигтай, зах зээлийн зарчимд нийцсэн аргаар хийх, шударгаар үнэ тогтоох, дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах зорилгоор эрдэс баялгийн бирж байгуулах;

3.7.6.төрийн байгууллагын үйлчилгээг сайжруулж, нээлттэй, ил тод, үр ашигтай болгох ба эрдэс баялгийн салбар хариуцсан Засгийн газрын бүх шатны байгууллагын ажлын тогтолцоо, зөвшөөрөл олголт, стандарт, хугацаа зэргийг нийтэд мэдээлж, иргэний нийгмийн хяналтыг тогтоох;

3.7.7.эрдэс баялгийн салбарын мэргэжлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын тогтолцоог бэхжүүлж, хариуцлагын механизмыг боловсронгуй болгох;

3.7.8.ашигт малтмалын төрлөөс үл хамааран геологийн судалгааны ажлыг цогцоор нь иж бүрэн хийж гүйцэтгэх үндэсний геологийн албыг олон улсын жишгээр байгуулж, удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг нэгдмэл, оновчтой болгож тогтвортой ажиллуулах;

3.7.9.эрдэс баялгийн экспортын гол нэрийн бүтээгдэхүүний ангиллыг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, үйл ажиллагааны бүхий л түвшинд мөрдлөг болгох;

3.7.10.ашигт малтмалыг түүхий хэлбэрээр экспортлох явдлыг үе шаттайгаар бууруулж, нэмүү өртөг шингэсэн, хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, олон улсын зах зээлийн үнээр борлуулах боломжийг бүрдүүлж, эрдэс баялгийн салбараас орох орлогыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцох арга, аргачлалыг боловсронгуй болгох;

3.7.11.эрдэс баялгийн салбар дахь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор төрийн болон



нутгийн захиргааны байгууллагын үйлчилгээг нэгдмэл бодлогоор хүргэж, хоорондын уялдаа холбоог сайжруулах;

3.7.12.эрдэс баялгийн салбарын үндэсний хүний нөөцийг бэлтгэхэд онцгой анхаарч, нарийн мэргэжлийн мэргэшсэн инженер, техникийн ажилтныг дотоод, гадаадын зохих шатны сургуульд бэлтгэж, чадавхжуулах;

3.7.13.эрдэс баялгийн салбарын эрдэм шинжилгээний байгууллагын уялдаа холбоо, үйл ажиллагааг сайжруулж, салбарын нийтлэг стратеги төлөвлөлт, судалгаа ба хөгжлийн төсөл, хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн замаар хэрэгжүүлэх.

### **Дөрөв.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн**

#### **4.1.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам:**

4.1.1.Засгийн газар, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын холбогдох агентлаг, аж ахуйн нэгж төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу төлөвлөгөө батлан, биелэлтийг зохион байгуулах;

4.1.2.Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хүрээнд төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг бусад салбарын бодлоготой уялдуулж төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

4.1.3.Засгийн газар төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, стратегийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсөв, төрийн мөнгөний бодлогод тусган төлөвлөж хэрэгжүүлэх;

4.1.4.уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт-шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэн дүгнэж, тухайн жилийн хэрэгжилтийг дараа жилийн эхний улиралд багтаан Засгийн газарт тайлагнаж байх;

4.1.5.хяналт-шинжилгээ, үнэлгээг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, мэргэжлийн холбоод, шинжлэх ухааны болон



төрийн бус байгууллагын оролцоотойгоор хийж байх. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт бүрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлттэй байх;

4.1.6.эрсдэл үүсч болзошгүй орчныг байнга хянаж, дунд болон богино хугацааны төлөвлөлтийн хүрээнд хариу арга хэмжээ авч, шуурхай шийдвэрлэж байх.

#### **4.2.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат:**

4.2.1.эрх зүйн орчныг сайжруулж, холбогдох дүрэм, журам, хөтөлбөр, төслийг боловсруулах (2014, 2015 он);

4.2.2.хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх (2014-2025 он);

4.2.3.эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийн дунд шатны тайланг дүгнэж, цаашдын зорилтын хэрэгжилтийг хангах (2020, 2025 он).

#### **4.3.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн:**

4.3.1.геологийн судалгаа, хайгуулын ажлыг төрийн бодлогын дагуу гүйцэтгэж, улсын эрдэс баялгийн нөөцийг өсгөж, уул уурхайн салбарын урт хугацааны тогтвортой хөгжлийн суурийг бүрдүүлэх;

4.3.2.эрдэс баялгийн нөөцийг иж бүрэн зохистой түвшинд олборлож, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай технологи ашиглаж, боловсруулалтын түвшинг ахиулснаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрөл нэмэгдэх;

4.3.3.олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаанд нэгдсэн стандартыг мөрдүүлж, үйлдвэрлэлийн бүх дамжлага, шатанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлснээр үйлдвэрлэлийн осол буурах;

4.3.4.уул уурхайн төслийг дагаад дэд бүтцийн хөгжлийн /замын сүлжээ, цахилгаан станц, хот, суурин газар/ төлөв тодорхой болж, урт хугацааны төлөвлөлт хийх боломжтой болох;

4.3.5.томоохон хэмжээний үйлдвэрлэлийн төвүүд бий болсноор хүн амын хэт төвлөрөл саарах;

4.3.6.эрдэс баялгийн болон дэд бүтцийн салбарын мэргэжлийн хүний нөөц бэлтгэгдэж, үндэсний мэргэжилтэй ажиллагсдын тоо, ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл буурах;



4.3.7.байгаль орчныг хамгаалах, уурхайг хаах, нөхөн сэргээх, урт хугацааны мониторинг хийх үйл ажиллагаа нь хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу цэгцтэй, дэс дараалалтай, хариуцлагатай болох;

4.3.8.экологийн тэнцвэрт байдлыг хангах, эрүүл, эко-хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор гол, мөрний урсац бүрэлдэх эх, ай сав, ойн бүс, тариалангийн талбай, шимт бэлчээр, говийн баянбүрд, нуур, цөөрмийн орчимд олборлолт, боловсруулалтын үйл ажиллагааг хязгаарлаж, иргэдийн эрүүл хүнс хэрэглэж, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;

4.3.9.эрдэс баялгийн салбарын бүх шатны үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу явагдаж олон нийтэд нээлттэй, ил тод байж, шинээр хууль тогтоомж, журам боловсруулах, томоохон хэмжээний төсөл хэрэгжүүлэхэд олон нийтийн саналыг хүлээн авч, шийдвэр гаргахад тусгаж байх эрх зүйн орчин бүрдсэн байх;

4.3.10.өнөөгийн эрдэс баялгийн салбарт бизнесийн таатай орчин бүрдэн, эрдэс баялгийн бирж дээр эрдсийн бүтээгдэхүүний арилжаа нээлттэй, олон улсын жишгийн дагуу явагдах орчин бүрдэх.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар  
хот

### **“Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 98 дугаар тогтоолын хавсралтын 4.2.5 дахь заалтын “болон дотоодын” гэснийг хассугай.

2.Энэ тогтоолыг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 9 дүгээр  
сарын 6-ны өдөр

Дугаар 317

Улаанбаатар  
хот

### Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай

Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, төсвөөс эргэн төлөгдөх төлбөрийг жил бүрийн улсын төсөвт үе шаттайгаар тусгахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгасугай.

3. Жагсаалтад орсон авто зам, боловсролын салбарын төслүүдийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг зарлах болон шууд гэрээний хэлэлцээг хийхдээ багцалж эсхүл хэсэгчилсэн байдлаар зохион байгуулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт зөвшөөрсүгэй.

4. Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор төслийн төсвөөс эргэн төлөгдөх төлбөрийг жил бүрийн орон нутгийн төсөвт суулган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлд үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ЭДИЙН ЗАСГИЙН  
ХӨГЖЛИЙН САЙД**

**Н.БАТБАЯР**

ТӨРИЙН ӨМЧИЙН КОНЦЕСССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

| №   | Концесссын зүйлийн нэр  | Концесссын зүйлийн тодорхойлолт  | Концесссын төрөл                                      | Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ  | Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх | Уралдаант шалгаруулалт явуулах шууд гэрээ байгуулах эсэх |
|---|---|--|---|--|--|--|
| 1. Дэд бүтэц, барилга байгууламжийн төслүүд |   |  |   |  |  |  |
| 1   | Улаанбаатар хотын баруун талд тээвэр ложистикийн төв төсөл    | Бараа материал ачиж, буулгах, хадгалах, борлуулах төв барих.                             | Зураг төсөл боловсруулах-барих-өмчлөх-ашиглах         | Улаанбаатар хотын баруун талд бараа материал борлуулах тээвэр ложистикийн төв барих.                 | Судлан шийдвэрлэх  | Уралдаант шалгаруулалт явуулах                           |
| 2   | Улаанбаатар хотын зүүн талд тээвэр ложистикийн төв төсөл      | Бараа материал ачиж, буулгах, хадгалах, борлуулах төв барих.                             | Зураг төсөл боловсруулах-барих-өмчлөх-ашиглах         | Улаанбаатар хотын зүүн талд бараа материал борлуулах тээвэр ложистикийн төв барих.                   | Судлан шийдвэрлэх  | Уралдаант шалгаруулалт явуулах                           |
| 3   | "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр төсөл                        | 50 сумын инженерийн шугам сүлжээг барьж байгуулах.                                       | Барих-өмчлөх-ашиглах                                  | -Цэвэр усны эх үүсвэр<br>-Усан сан<br>-Цэвэрлэх байгууламж<br>-Шугам сүлжээ<br>-Дулааны шугам сүлжээ | Шаардлагагүй   | Уралдаант шалгаруулалт явуулах                           |
| 4   | Батлан хамгаалахын их сургуулийн 500 оюутны дотуур байр төсөл | Батлан хамгаалахын их сургуулийн хашаанд 500 оюутны дотуур байрыг барьж бүрэн тохижуулах | Зураг төсөл боловсруулах-барих-түрээслүүлэх-шилжүүлэх | 500 оюутны дотуур байр барьж бүрэн тохижуулах.   | Судлан шийдвэрлэх  | Уралдаант шалгаруулалт явуулах                           |





|   |   |  |  |   |                                |
|---|---|--|--|---|--------------------------------|
| 5 | Уул уурхай, металлургийн цогцлолбор байгуулах төсөл       | Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн орд газруудыг ашиглан эдийн засгийн эргэлтэд оруулах. Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх. | Шинэчлэн сайжруулах- барих -ашиглах-шилжүүлэх. Барих-шилжүүлэх | -Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөрлөгийн цогцлолбор байгуулах.<br>-Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйин ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол", ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртлэх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих.<br>-Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хүнд даацын хатуу хучилттай авто зам барих.<br>-Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, өргөтгөл, дэд станцын хамт барих. | Шууд гэрээ байгуулах           |
| 6 | Хүний хөгжлийн төв цогцлолбор төсөл                       | Хүний хөгжлийн төв цогцлолборыг Баянгол дүүрэг, Архангай аймагт барьж байгуулах.   | Барих-ашиглах -шилжүүлэх                                       | Хүний хөгжлийн төв цогцлолборын барилгыг барьж бүрэн тохижуулах.  | Шууд гэрээ байгуулах           |
| 7 | Улаанбаатар хотын чуулга уулзалт, үзэсгэлэнгийн төв төсөл | Улаанбаатар хотыг олон улсын арга хэмжээний нэг төв болгох зорилгоор олон улсын хурлын цогцлолбор барьж байгуулах.   | Барих- өмчлөх -ашиглах   | Хан-Уул дүүрэгт дэлхийн жишигт нийцсэн олон улсын хурлын цогцлолборыг барьж бүрэн тохижуулах.   | Уралдаант шалгаруулалт явуулах |



| 2. Авто замын төслүүд |  |   |                 |   |                   |                                |
|-----------------------|--|---|-----------------|---|-------------------|--------------------------------|
|                       | Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам төсөл:<br>8.1. 60.0 км авто зам<br>8.2. 54.0 км авто зам  | Завхан аймгийг нийслэлтэй холбох авто зам барих.  | Барих-шилжүүлэх | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх. | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 8                     | Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам төсөл:<br>8.1. 60.0 км авто зам<br>8.2. 54.0 км авто зам  | Завхан аймгийг нийслэлтэй холбох авто зам барих.  | Барих-шилжүүлэх | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх. | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 9                     | Баянхонгор-Алтай чиглэлийн 256.1 км хатуу хучилттай авто зам, Гүүрийн төсөл:<br>9.1. 2.9 км Гүүр<br>9.2. 63.0 км авто зам<br>9.3. 63.5 км авто зам<br>9.4. 78.9 км авто зам<br>9.5. 47.8 км авто зам | Говь-Алтай аймгийг нийслэлтэй холбох авто зам барих.  | Барих-шилжүүлэх | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх. | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 10                    | Алтай-Дарви чиглэлийн 263 км хатуу хучилттай авто зам төсөл<br>10.1. 80 км авто зам<br>10.2. 85 км авто зам<br>10.3. 98 км авто зам  | Говь-Алтай аймгийг Ховд аймагтай холбох авто замын сүлжээний хэсэг бөгөөд аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох. | Барих-шилжүүлэх | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх. | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 11                    | Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Согино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл<br>11.1. 50 км авто зам<br>11.2. 50 км авто зам<br>11.3. 67 км авто зам                                 | Завхан аймгийг Увс аймагтай холбох авто замын сүлжээний хэсэг бөгөөд аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох.      | Барих-шилжүүлэх | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх. | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |



|    |   |  |                 |   |                   |                               |
|----|---|--|-----------------|---|-------------------|-------------------------------|
| 12 | Сонгино сум-Хяргас нуурын зүүн хааяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл<br>12.1 65.5 км авто зам<br>12.2 70 км авто зам  | Завхан аймгийг Увс аймагтай холбох авто замын сулжээний хэсэг бөгөөд аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох. | Барих-шилжүүлэх | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх. | Судлан шийдвэрлэх | Урлдаант шалгаруулалт явуулах |
| 13 | Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 232 км хатуу хучилттай авто зам төсөл.<br>13.1. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс Могойн гол хүртэлх 70.0 км авто зам<br>13.2. Могойн голоос Шарбулаг хүртэлх 60 км авто зам<br>13.3. Шарбулагаас Рашаант хүртэлх 55 км авто зам<br>13.4. Рашаангаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 47 км авто зам | Нийслэлтэй холбох авто замыг 3 гүүрийн хамт барих.   | Барих-шилжүүлэх | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх. | Судлан шийдвэрлэх | Урлдаант шалгаруулалт явуулах |
| 14 | Даланзадгад-Цогтцэций (Тавантолгой) чиглэлийн 94.8 км хатуу хучилттай авто зам төсөл  | Хатуу хучилттай авто зам барих.  | Барих-шилжүүлэх | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх. | Судлан шийдвэрлэх | Урлдаант шалгаруулалт явуулах |



|    |   |  |                           |  |                   |                                |
|----|---|--|---------------------------|--|-------------------|--------------------------------|
| 15 | Хужирт-Төвхөн хийд-Улаанцутгалан чиглэлийн 90,1 км хатуу хучилттай авто зам төсөл<br>15.1. Хужиртаас Төвхөн хийд хүртэлх 48 км авто зам<br>15.2. Орхон-Нарийн голын уулзвараас Бат-Өлзий хүртэлх 42,1 км авто зам | Хужирт-Төвхөн хийд-Улаанцутгалан чиглэлийн аялал жуулчлалын зам                      | Барих-шилжүүлэх           | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх.                                | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 16 | Дашинчигэн-Өгийнуурын замаас Хөшөө цайдам чиглэлийн 30 км хатуу хучилттай авто зам төсөл  | "Алтан цагираг" Жуулчлалын хатуу хучилттай авто зам.                                 | Барих-шилжүүлэх           | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх.                                | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 17 | Хэнтий аймгийн Биндэр сумын Ононгийн гүүрийг шинэчлэх төсөл   | Гүүрийг шинэчилж барих.  | Барих-шилжүүлэх           | Гүүрийн барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх.                                   | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 18 | Мандал сум Зүүн Хараа чиглэлийн 15,8 км хатуу хучилттай авто зам төсөл  | Бороогоос Мандал сум Зүүн Хараа хүртэлх хатуу хучилттай авто зам барих.              | Барих-шилжүүлэх           | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх.                                | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 19 | Чойр-Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам төсөл   | Чойр-Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам барих.                       | Барих-шилжүүлэх           | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх.                                | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 20 | Тавантолгой-Ханбогд-Ханги чиглэлийн авто зам төсөл  | Ашигт малтмалын болон нийтийн хэрэгцээний тээвэрлэлтэд ашиглах 435 км авто зам барих | Барих- ашиглах -шилжүүлэх | Хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй      | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 21 | Нарийнсухайт-Шмээсхүрэн чиглэлийн авто зам төсөл  | Ашигт малтмалын болон нийтийн хэрэгцээний тээвэрлэлтэд ашиглах 50 км авто зам барих  | Барих-ашиглах -шилжүүлэх  | Хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх               | Шаардлагагүй      | Уралдаант шалгаруулалт явуулах |

|                             |  |  |   |   |                   |                               |
|-----------------------------|--|--|---|---|-------------------|-------------------------------|
| 22                          | Баянзүрхийн товчоо-Налайх-Чойрын уулзаар хүртэлх 17,5 км хурдны авто зам төсөл | Баянзүрхийн товчоо-Налайх-Чойрын уулзаар хүртэлх 17,5 км хурдны авто зам барих   | Барих-шилжүүлэх   | Авто замын берилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх  | Судлан шийдвэрлэх | Шууд гэрээ байгуулах          |
| 23                          | Нисэх онгоцны буудал болон нийслэлийг холбосон авто зам төсөл                  | Улаанбаатар хотыг Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудалтай холбох хурдны 35 км авто зам барих  | Барих-шилжүүлэх   | Хурдны авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх   | Шаардлагагүй      | Шууд гэрээ байгуулах          |
| 24                          | Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн Хурдны авто зам төсөл               | Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн транзит тээврийн хурдны 997 км авто зам барих.  | Барих-ашиглах -шилжүүлэх                                    | Хурдны авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх   | Шаардлагагүй      | Уралаант шалгаруулалт явуулах |
| 3. Хоолойн тээврийн төслүүд |  |  |   |   |                   |                               |
| 25                          | Багануур-Улаанбаатар чиглэлийн хоолойн тээвэр төсөл                            | Эрчим хүчний нүүрс тээвэрлэх хоолой барих.   | Барих- өмчлөх -ашиглах                                      | Хоолойн тээврийн иж бүрэн байгууламжийг барин өмчлөн ашиглах.   | Шаардлагагүй      | Шууд гэрээ байгуулах          |
| 26                          | Тавантолгой-Гашуунсухайт боомт чиглэлийн хоолойн тээвэр төсөл                  | БНХАУ-руу экспортолох эрчим хүчний нүүрс тээвэрлэх хоолой барих.   | Барих-өмчлөх -ашиглах                                       | Хоолойн тээврийн иж бүрэн байгууламжийг барин өмчлөн ашиглах.   | Шаардлагагүй      | Шууд гэрээ байгуулах          |
| 4. Нисэх буудлын төслүүд    |  |  |   |   |                   |                               |
| 27                          | Налайх дахь иргэний болон тусгай зориулалтын нисэх онгоцны буудал төсөл        | Налайх дахь аэродромыг шинэчлэн сайжруулан иргэний болон тусгай зориулалтын нисэх онгоцыг хүлээж авах олон улсын стандартад нийцсэн нисэх онгоцны буудал болгох. | Шинэчлэн сайжруулах тоноглох-түрээслүүлэх ашиглах-шилжүүлэх | Аэродромд ерөнхий зориулалтын агаарын хөлөг буух зориулалт бүхий үндсэн болон буух зурвасыг сайжруулах, тоног төхөөрөмжийг суурилуулах. | Судлан шийдвэрлэх | Шууд гэрээ байгуулах          |



| 5. Эрчим хүчний төслүүд |   |  |   |   |                   |                                |
|-------------------------|---|--|---|---|-------------------|--------------------------------|
| 28                      | Далнаадагд дахь нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгон шинэчлэн барих төсөл | Далнаадагд дахь нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгон шинэчлэн барих.   | Зураг төсөл боловсруулах- барих-ашиглах-шилжүүлэх | Нисэх онгоцны буудлыг шинэчлэн, бүүх, хөөрөх зурвасыг сайжруулах, тоног төхөөрөмжийг суурилуулах.                     | Судлан шийдвэрлэх | Урладаант шалгаруулалт явуулах |
| 29                      | Багануурын цахилгаан станц төсөл  | Багануурын нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан станц барих.  | Барих-ашиглах-шилжүүлэх                           | 700 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих.  | Судлан шийдвэрлэх | Урладаант шалгаруулалт явуулах |
| 30                      | Шивээ-Овоогийн цахилгаан станц төсөл  | Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх.  | Барих-өмчлөх -ашиглах-шилжүүлэх                   | 270 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих.  | Судлан шийдвэрлэх | Урладаант шалгаруулалт явуулах |
| 31                      | Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц төсөл              | Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих.  | Барих-шилжүүлэх                                   | 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих.   | Судлан шийдвэрлэх | Урладаант шалгаруулалт явуулах |
| 32                      | Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл                                 | Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих.  | Барих-шилжүүлэх                                   | 220 кВ-ын 2 хэлхээт агаарын шугам, дэд станц барих.   | Судлан шийдвэрлэх | Урладаант шалгаруулалт явуулах |
| 33                      | Чандганы цахилгаан станц, Багануур-Өндөрхаан агаарын шугам барих төсөл                            | Хэнтий аймгийн Мөрөн сумын Чандганы нүүрсний уурхайг түшиглэж 600 МВт-ийн хүчин чадал бүхий цахилгаан станцыг барьж өмчлөн ашиглаж, Багануур-Өндөрхаан агаарын шугамыг барьж төрийн өмчид шилжүүлэх. | Барих-өмчлөх-ашиглах Барих-шилжүүлэх              | 600 МВт-ийн хүчин чадал бүхий цахилгаан станц, Багануур-Өндөрхаан цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих. | Судлан шийдвэрлэх | Урладаант шалгаруулалт явуулах |
| 34                      | Өндөрхаан-Чойбалсангийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц төсөл                        | Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц.  | Барих-шилжүүлэх                                   | 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих.   | Судлан шийдвэрлэх | Урладаант шалгаруулалт явуулах |

|    |  |  |                          |  |                   |                                |
